

ДӨРВӨЛЖИН БИЧГИЙН СУДАЛГАА

(Тэмдэглэл)

Б.Түвшинтөгс

Монголчууд бид арваад нэрийн бичиг зохион хэрэглэж ирсний дотор хэрэглэгдэж байсан хүрээ хэмжээгээрээ дөрвөлжин бичиг Юань улс (1271-1368)-ын харьяанд байсан олон хэлтний дунд түгэн дэлгэрсэн тул олон улсын шинжтэй юм.

Дөрвөлжин бичгийг Хубилай сэцэн хаан (1215-1294)-ы зарлигаар Пагва лам хэмээн алдаршсан Лодойжалцан (1235-1280) зохиожээ. Энэ талаар “Юань улсын судар” түүхэн сурвалжид Хубилай сэцэн хааны Жи Юанийн 6-р он буюу 1269 оны үйл явдлын хэсэгт дурдахдаа Хаврын дунд сард Пагва лам бичиг бичиж дуусаад Шизу хаанд хүргэж өгөв. Тэр бичгийн үсэг мянга илүү ажээ. Түүний эх үсэг нь дөчин нэг. Нааш цааш дээд доодыг солицуулж хоёр гурав, дөрөв таван үсгийг нийлүүлж бичжээ. Тэр бичгийг дэлхий дахинд тархаан жуу бичиг буулгав.

Энэ бичгийн үгийг би сэтгэвээс бичгийн үсгээр үгийг бичиж үйл явдлыг тэмдэглэх буй. Энэ эртнээс эдүгээд хүртэл тогтоосон ёс болой. Манай улс умард газраас гарч тугдмаар өөдөгш болоод язгуураас зүг шударгын тулд бичгийг эс үүсгэжээ. Хэрвээ бичгийг хэрэглэх бөгөөс л, Хятад улс, Уйгур улсын бичгээр манай улсын үгийг ухмуй. Дай Ляо улс, Алтан улс хийгээд аливаа улсын шинжилбээс өөрийн улсын хэлээр бичиг буй ажгуу. Эдүгээ манай улсын хэлээр бичгийн төрийг улам үүсгэн бөгөөтөл бид бичгийг эс хэрэглэвээс төр ёс маань омтгой болмуй хэмээн зарлиг болоод төдий улсын багш Пагва ламд тушаалгаж тугдмаар үүсгэн монгол бичгийг бичүүлэв. Аливаа бичгийг орчуулж бичвээс бээр үг нь найртай болоод аливаа үйлийн шалтгаан нь тодорхойёо ухагдму. Үүнээс хойш тамганы бичиг тархах бичгийг бичгийг Монголын хэлээр бичээд бус улсын бичгийг хослон бичигтүн

хэмээн буулгалаа гэдгийг тэмдэглэжээ. Харин энэхүү бичгийг чухам юуны тулд зохиосон талаар тодорхой мэдээ хараахан алга. Судлаачид Юань улсын захиргаанд олон үндэстэн, олон хэлтэн багтаж байсан тул аль нэгнийх нь бичгийг нийтэд нь хэрэглүүлэхээр авахад хүрвэл бусад нь эсэргүүцэх магадтай, тэгээд ч тэдгээр олон хэлэнд жигд тохирох бичиг байсан уу (Шагдарсүрэн, 2001:81) гэсэн асуудал дэвшүүлжээ. Мөн зарим судлаач дөрвөлжин бичиг зохиосноор Хятадын утга үсэгт бичгийг халж авианы үсэгт бичигтэй болгосноор хятад хэлтнүүд харилцан бие биетэйгээ үл ойлголцох болон задарч нэгдсэн зохион байгуулалтаа алдахад хүргэхийн тулд зохиосон (Лувсандэндэв, 1982:307) гэж үзжээ. Юутай ч дөрвөлжин бичгийг монголчуудаас гадна Юань улсын харьяанд байсан түрэг, самгарди, төвд, хятад хэлтнүүд Хааны зарлигаар хэрэглэж, эдүгээ тэрхүү цаг үеийн гэрч дээрх хэлүүдээр тэмдэглэсэн дөрвөлжин бичгийн дурсгалууд хадгалагдаж иржээ. Эдгээр дурсгал дотор дөрвөлжин үсгийн монгол дурсгал тодорхой байр суурь эзэлнэ.

Дөрвөлжин бичгийн талаарх анхны хэмээн үзэж болохуйц танилцуулга, судалгааг Юань улсын бүрэлдэхүүнд байсан угсаатнууд, тухайлбал Хятадын бичгийн хүмүүс болон Солонгосын түүх тэмдэглэгчид үлдээжээ. Үүнд, Хайсан хүлэг хааны үе буюу 1308 онд дөрвөлжин үсгээр нангиад хэлээр бичих аргыг үзүүлсэн “Монгол үсгийн дууриан” хэмээх 2 дэвтэр ном, XIII-XIV зууны үед зохиосон хууль зүйн холбогдолт лавлах зэрэгт дөрвөлжин бичгийн цагаан толгойн үсгүүдийг ханз үсгээр галиглаж тэмдэглэсэн байдаг.

Солонгосын “Ли улсын судар”-т 1423 оны үйл явдлын талаар өгүүлэхдээ “Гадаад хэргийг эрхлэх газраас ванд айлтгасан нь монгол хэлнээ хоёр зүйл бичиг бий бөгөөд нэгдүгээрт вүйолжин, хоёрдугаарт чөбавөлжин юм. Үүний өмнө чөбавөлжин нь хааны зарлиг номд хэрэглэгдэж байсан ба вүйолжинийг жирийн хэрэгт хэрэглэж байсан. Одоо оюутан зөвхөн вүйолжин бичгийг үзэж байна. Иймд чөбавөлжин бичгийг хичээллэх хүн цөөн байгаа

тул одооноос эхлэн дөрвөн улирлын эхний сар бүр монгол сурлагын шалгалт авахдаа чөбавөлжинийг хамт авч байя гэснийг Ван соёрхов” (Сумьяабаатар, 1975:34) хэмээжээ. Энэхүү тэмдэглэлд буй *вүйолжин* гэдэг нь уйгуржин, *чөбавөлжин* гэдэг нь дөрвөлжин гэсэн үгсийн солонгос галиг болно. Харин Европ дахинд дөрвөлжин бичгийн талаар анх Германы дорно дахин судлагч, аялагч Юлиус Генрих Клапрот (Julius Heinrich Klapproth), Францын дорно дахин судлаач Абель Ремюза (Jean Pierre Abel Remusat) нар танилцуулжээ. Ийнхүү XIX зууны эхэн үед эхэлсэн дөрвөлжин бичгийн судалгаа өнөөдөр ч гэсэн олон тооны бүтээл, туурвилаар баяжсаар байна.

1618 онд модон бараар хэвлэгдсэн Ши-мо цзянь-хуа хэмээх Хятадын зарим сүм хийдийн болон бунхны бичээсийн эмхэтгэлд Юань улсын Буянт хаан (1285-1320)-аас Юань ши сянийн Кай хуа си сүмд буулгасан зарлигийн дөрвөлжин үсгээрх монгол бичээсийг нэрт дорно дахин судлаач Германы эрдэмтэн Ханс Конон фон де Габеленц (Hans Conon von der Gabelentz) судалж хэвлүүлсэн билээ. Тэрбээр уг бичээсийг эхлээд хамгийн сүүлийн мөрөөс нь эхэлж галиглаад дараа нь дарааллын дагуу галиглан буулгаад үг, хэллэгүүдийг нь тайлбар, герман хэлээрх орчуулгын хамт хэвлэжээ. Ийнхүү эхэлсэн дөрвөлжин үсгийн монгол дурсгалыг нээж илрүүлэх, бүртгэх, судлах ажил дотоод, гадаадын үе үеийн судлаачдын хүчин чармайлтаар өргөжсөөр 1930-аад он гэхэд тухайн үед мэдэгдээд байсан дөрвөлжин бичгийн монгол дурсгалуудыг нэгтгэн гаргах шаардлагатай болсон байна. Иймд Польшийн монголч эрдэмтэн М.Левицки (M.Lewicki) 1937 онд Мангалын зарлиг, Буянт хааны 2 зарлиг, Цавчаал боомтын баруун, зүүн ханын бичээс, 1306 болон 1307 оны тунхаг бичгүүд гэсэн нийт 6 дурсгалыг үсгийн галиг (зөвхөн Цавчаал боомтын бичээст үсгийн болон дуудалгын галиг хийсэн), франц хэлээрх орчуулга, тайлбартай хэвлэжээ. Харин энэхүү бүтээл хэвлэгдэхээс өмнө Зөвлөлтийн монголч эрдэмтэн, Дэлхийн II дайны дараагаар Америкийн иргэн болсон Н.Н.Поппе тухайн үед мэдэгдээд байсан дөрвөлжин үсгийн монгол дурсгалуудыг нэгтгэн судалсан бүтээл туурвисан хэдий ч тодорхой шалтгааны улмаас хэвлэгдэхгүй байсаар 1941 онд л олон нийтийн хүртээл болсон байна. Тодруулбал, Зөвлөлтийн ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэнгээс гаргасан мэдэгдэлд “Зөвлөлтийн ШУА-ийн сурвалжлагч гишүүн Н.Н.Поппе *Дөрвөлжин бичиг* хэмээх бүтээлээ 1937 оны эхээр туурвиж дууссан ч зохиогч өөрөө бүтээлдээ авч үзсэн дурсгалуудаа зөвхөн галиглаад зогсохгүй дөрвөлжин бичгийн үсгийг нь хэвлэлийн үсгээр хэвлэх шаардлагатай гэж үзсэн учир тухайн үедээ хэвлэгдээгүй юм. Маш ховор хэрэглэдэг тэдгээр үсгийг бэлтгэх нь техникийн хувьд маш их төвөгтэй байлаа. Иймээс зохиогч эхний санаасаа буцаж боломжит аргаар хэвлэхийг зөвшөөрсөн юм. Энэ хугацаанд Marian Lewicki. *Les inscriptions mongoles inedites en ecriture carree* (Wilno, 1937) хэмээх бүтээл хэвлэгдэн гарсан ба тэнд Н.Н.Поппегийн судалсан дөрвөлжин бичгийн монгол дурсгалуудын зарим нь оржээ. Ийм учир шалтгаанаар Н.Н.Поппе бүтээлээ М.Левицкигээс өмнө туурвисан боловч хойно нь хэвлүүлж байна” (Поппе, 1941:166) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Н.Н.Поппе энд дурдсан бүтээлдээ тухайн үед мэдэгдээд байсан дөрвөлжин бичгийн бүхий л дурсгалыг хамруулсан байна. Гагцхүү Буянт хааны 1318 оны зарлигийг гэрэл зураг бүдэг хэвлэгдсэн, уул дурсгал гэмтэл ихтэй зэрэг шалтгаанаар бүтээлдээ оруулаагүй аж. Ийнхүү тэрбээр уг дурсгалуудыг үсгийн болон дуудалгын галиг, орос орчуулга, эхийн зургийн хамт оруулахаас гадна бичээсийн үг, хэллэгтэй холбоотой 202 тайлбар, толь бичиг, дэлгэрэнгүй номзүй дагалдуулан хэвлэжээ. Түүнээс гадна уг бүтээлийн хамгийн үнэ цэнэтэй зүйл нь дөрвөлжин бичгийн үсэгзүй болон үгзүйн судалгаа болно. Н.Н.Поппе дөрвөлжин бичгийн монгол хэлээрх дурсгалд тохиолддог 39 үсгийг бичлэгийн хувилбартайгаар нь хүснэгтээр үзүүлээд үсэг тус бүрийг тодорхойлжээ. Түүнчлэн зөв бичихзүй хийгээд авиазүйн онцлогийг дэлгэрэнгүй тодорхойлсон байна. Мөн дөрвөлжин бичгийн монгол дурсгалын хэлийг тодорхой жишээ баримттайгаар тайлбарлан үзүүлсэн билээ. Энэ бүхэн бол дөрвөлжин бичгийн авиа зүй болон үгзүйг, түүнчлэн дөрвөлжин бичгийн монгол дурсгалын хэлийг судлах үндсэн зарчмыг тогтоосон, одоо ч ач холбогдлоо өчүүхэн ч алдаагүй бүтээл болсон юм. Хэдийгээр уг бүтээл

хэвлэгдсэнээс хойш дөрвөлжин үсгийн монгол дурсгалууд нэмж олдсоор өнөөгийн байдлаар 70 гаруй болоод байгаа ч судлах, хэвлэн нийтлэхэд Н.Н.Поппегийн дээрх бүтээл чухал гарын авлага болсоор байна. Үүнд л Н.Н.Поппегийн уг бүтээлийн мөнхийн чанар оршино.

Н.Н.Поппе “Дөрвөлжин бичиг” хэмээх энэ бүтээлийнхээ талаар “Би дөрвөлжин бичиг болон бичгийн хэлийг нь судалсан нэг сэдэвт бүтээлээ 1941 онд орос хэлээр дурсгал бичгүүдийнх нь хамтаар хэвлүүлсэн буй. Ном маань Герман ЗХУ-д 1941 оны зургадугаар сарын 22-нд довтолсноос хэдхэн хоногийн дараа гарсан тул Өрнөдөд огт хүрээгүй юм. Харин өөртөө ганц хувийг хадгалж үлдсэн байсныг маань Жон Р.Крюгер 1955-56 онд англи хэлэнд орчуулж 1957 онд хэвлүүлсэн билээ. Дурсгалуудынх нь ихэнх нь чулуун дээр сийлсэн лам хуврагуудыг татвараас чөлөөлөх бичиг байдаг. <...> Өөрийнхөө бичсэн бүтээлүүд дотроос бусдаасаа илүү чухал нь хэмээн дөрвөлжин бичгийн дурсгалын тухай ном, Мукаддимат ал-Адаб толь, Лейдэний гар бичмэлүүдийн талаарх өгүүлэл гурваа үзэж байна. Энэ гурван бүтээл дэх баримтууд хэзээд хэрэгцээнээс гарахгүй” (Поппе, 2008:247, 258) хэмээн дурссан байдаг. Н.Н.Поппегийн “Квадратная письменность” хэмээх бүтээлийн хэвлэн нийтлэлийн мэдээнд 1941 оны VI сарын 10-нд хэвлэлд шилжиж 800 хувь хэвлэгдсэнийг тэмдэглэжээ. Дэлхийн II дайн эхлэхийн өмнөхөн хэвлэлд орж дайн эхэлсний дөнгөж дараа цөөн тоотой хэвлэгдэн гарсан энэ бүтээл Өрнөдийн уншигчдад төдий л хүрээгүй тул зохиогч өөрөө зарим нэмэлт хийн англи хэлээр гаргажээ. Үүний өмнө 1955 онд япон хэлээр бүрэн бус орчуулга хэвлэгдсэн нь бий.

Дэлхийн II дайны үед Н.Н.Поппе гэр бүлийн хамт Европ руу гарч улмаар дайны дараа АНУ руу цагаачлан тэндэхийн иргэн болсон билээ. Түүний энэ үйлдлийг эх орон - ЗХУ нь буруушаан үзсэн ба тухайн үеийн БНМАУ-д мөн адил дүгнэж байсан юм. Иймд манай судлаачдын хувьд Н.Поппегийн¹ бүтээл туурвил 1990-ээд он хүртэл хаалттай байлаа. Харин эрдэмтэн Х.Лувсанбалдан 1960-аад оны эхээр Өвөр Монголын Их Сургуульд ажиллах үедээ энэхүү бүтээлийг орос хэлнээс тайлбарын хэсгийг нь бага зэрэг товчлон орчуулж албан хэрэгцээнд зориулан монгол бичгээр хэвлэн гаргажээ. Гэсэн ч энэ бүтээл мөн зохиогчийн нэртэй холбоотойгоор монгол уншигчдын дунд тараагүй ба харин тус орчуулгын Дөрвөлжин бичгийн цагаан толгой, Дөрвөлжин бичгийн хэлний онцлог гэсэн хэсгийг А.Дамдинсүрэн гуай “Монгол дөрвөлжин бичиг” бүтээлдээ хэвээр ашигласан байдаг. Түүнчлэн 1986 онд хятад хэлээр орчуулж хэвлэжээ.

Энэхүү 2019 онд дөрвөлжин бичгийг зохиосны 750 жилийн ой тохиож буйд зориулан Н.Н.Поппегийн энэ бүтээлийг Х.Лувсанбалдан гуайн орчуулгаар хэвлэн нийтлээд байна. Ингэхдээ уг орчуулгыг орос болон англи хэвлэлтэй тулган хянан нягталсан болно. Түүнчлэн орос хэвлэлд буй Мангалын зарлигийн үсгийн галигт 'an-[s]i-'uaŋ хэмээх үгийг ŋan-[s]i-'uaŋ, Цавчаал боомтын бага бичээст ya-buq-c'i-na хэмээх үгийг ya-buq-c'i-n, 'a-pi-da гэхийг 'a-bi-da гэж галигласныг, мөн толь бичигт 3 үгийн хойно дурсгалын тоон дутаарыг орхисныг, 1 дурсгалын тоон дугаар ташаарсныг мөн beyede, ende, tere гэсэн гурван үг орхисныг эрдэмтэн Ё.Жанчивын ажигласнаар (2002:107-108) тус тус залруулж хэвлэжээ. Бас зохиогчийн анхны хүсэл дөрвөлжин бичгийн үсэг тус бүрийг хэвлэлийн үсгээр хэвлэх хүслийг хүндэтгэн үзэж үсгийн дугаарын өмнө дөрвөлжин бичгийн үсэг тус бүрийг хадаж оруулав.

Н.Н.Поппегийн энэхүү бүтээл хэвлэгдсэнээс хойш Л.Лигети (L.Ligeti, 1964; 1972; 1973), Зуунаст (Zunast, 1990; 1991), А.Дамдинсүрэн (1986), Ё.Жанчив (2002), Д.Төмөртоогоо (2002; 2010), Хөгжилт, Саруул (Hugjiltu & Sarula, 2004), Х.Курибаяши, Т.Мацукава (Kuribayashi & Matsukawa, 2016) нарын дөрвөлжин бичгийн монгол дурсгалуудыг бүртгэсэн, нэгтгэсэн бүтээлүүд гараад байна.

¹ Тэрбээр Америкийн иргэн болохдоо Николай Николаевич Поппе гэсэн овог нэрээ Николас Поппе хэмээн өөрчилсөн байна.

Номзүй

- Hugjiltu & Sarula.** 2004. *A collection of Phags-pa monuments in Mongolian.* 537 pp. (хятад хэлээр).
- Kuribayashi H. & Matsukawa T.** 2016. *Phags-pa Mongolian Documents in a collection of Historical Archives of Tibet.* CNEAS report №21. Sendai, 110 pp.
- Ligeti L.** 1964. *'Phags-pa irasos emlekek. Kancellariai iratok kinai atirasban.* (Monuments en ecriture phags-pa. Pieces de chancellerie en transcription chinoise. Mongol Nyelvemlektar-II). Budapest.
- Ligeti L.** 1972. *Monuments en ecriture 'Phags-pa. Pièces de chancellerie en transcription chinoise.* (Monumenta Linguae Mongolicae Collecta-III) Akadémiai Kiadó, Budapest. 197 pp.
- Ligeti L.** 1973. *Monuments en écriture 'phags-pa. Pièces de chancellerie en transcription chinoise.* (Indices Verborum Linguae Mongolicae Monumentis Traditorum- III), Akadémiai Kiadó, Budapest. 243 pp.
- Mongolian monuments in 'Phags-pa script.* Ed. by D.Tumurtogoo with the collaboration of G.Cecegdari. Taiwan, 2010, 280 pp.
- Zunast.** 1991. *The Mongolian monuments in 'Phags-pa script.* 228 pp. (хятад хэлээр).
- Дамдинсүрэн А.** Монгол дөрвөлжин бичиг. Уб., 1986 [1985], 228 х.
- Жанчив Ё.** 2002. *Дөрвөлжин үсгийн монгол дурсгал.* Monumenta Mongolica. Т-III. Уб., 196 х.
- Жанчив Ё.** 2002. *Монголын дөрвөлжин үсгийн судлалд профессор Н.Поппегийн оруулсан хувь нэмэр (Н.Н.Поппе. Квадратная письменность ном хэвлэгдсэний 60 жилийн ойд).* Studia Linguae. Т-VII (XXIX), 9-р дэв. Уб., х.93-108.
- Лувсандэндэв А.** 1982. *Хүрэл тамгын учир.* Дорно дахин судлалын асуудал. Уб., №1 (6), х.61-64.
- Поппе Н.** 2008. *Дуртгал.* Уб., 288 х.
- Поппе Н.** 1941. *Квадратная письменность.* М-Л., 168 стр.
- Сумъяабаатар Б.** 1975. *Монгол, солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал.* Уб., 228 х.
- Төмөртоого Д.** 2002. *Монгол дөрвөлжин үсэгийн дурсгалын судалгаа.* Уб., IV+182 х.
- Шагдарсүрэн Ц.** 2001. *Монголчуудын бичиг үсгийн товчоон.* Уб., 302 х.